

Жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
<p>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</p>	
<p>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</p>	<p>Баянгол Зочид Буудал ХК, УБГД: 000153763 ҮЦ код: BNG, Утас: 11-312255,</p>
<p>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</p>	<p>Монголын Хөрөнгийн Бирж</p>
<p>Бизнесийн үйл ажиллагааны салбар</p>	<p>Аялал жуулчлал /Зочид Буудал, Зоогийн газар/</p>
<p>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</p>	<p>423065 ширхэг</p>
<p>Жилийн эцсийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</p>	<p>Бэлтгэсэн: Ерөнхий Нябо-Д.Самданжамц Хянасан: ТУЗ-ын дарга Д.Аюуш</p>
1	<p>Санхүүгийн байдлын үзүүлэлт</p> <p>Орлогын тайлан</p> <p>Өмчийн өөрчлөлтийн тайлан</p> <p>Мөнгөн гүйлгээний тайлан</p>
	<p>Тайланг хавсаргав</p> <p>Тайланг хавсаргав</p> <p>Тайланг хавсаргав</p> <p>Тайланг хавсаргав</p>
1.1	<p>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</p>
<p>Дүгнэлтийг хавсаргав.</p>	
1.2	<p>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</p>
	<p>Хавсралтаар оруулав.</p>
2	<p>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад,дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийнүзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</p>

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Бие даалтын коэффициент 96% Өр эзний өмчийн харьцаа 4% Нийт ашгийн хувь 45% Цэвэр ашгийн хувь 45%
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлтүүд	Эргэлтийн харьцаа 16.3% Түргэн хөрвөх харьцаа 15.4% Авлагын эргэц 23.95%
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад,дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн,үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Гадаад орчинд түүхий эд материалын үнийн өсөлт, инфляци нэмэгдэх, гадаад валютын өсөлтийн улмаас бүтээгдэхүүний үнэд өөрчлөлт оруулсан.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн бүртгэгдсэн ажил, гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Зээл аваагүй.
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ Хийгдээгүй	
4	Цалин урамшууллын мэдээлэл Тус компани нь 2022 онд ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад цалин хөлс, урамшууллыг олгосон болно.	
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Хувьцаа эзэмшигчдийн хурал: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ХХІХ хурлыг 2022 оны 04-р сарын 28-ны өдрийн 15 цагт зохион байгуулсан. ТУЗ-ийн гишүүд: 2022.04.29-ны өдрийн ХЭХурлаар ТУЗ-д ажиллаж байсан 9 гишүүн (хараат бус 3 гишүүн, ердийн 6 гишүүн) дахин сонгосон.	
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	

	<p>Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид</p> <ol style="list-style-type: none"> 1. BILLY LIM SIN PAU BILLY LIM SIN PAU- 16.32 % 2. Халтмаа Баттуул- 16.3 % 3. Халтмаа Баттулга- 20 % 4. Халтмаа Цэндбаяр- 14.88 % 5. Баттуул Эрхэс- 7.58 % 	
8.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>	
	<p>Баянгол Зочид Буудал ХК нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцааг тайлант хугацаанд гаргаагүй болно.</p>	
9.	<p>Ногдол ашгийн мэдээлэл</p>	
	<p>Ковидын дараах шинэ хэвийн байдалд эргэн орж салбарын үйл ажиллагаа сэргэсний улмаас 2022 онд ашигтай ажилласан учраас Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн №05 тоот тогтоолоор 2022 онд нэгж хувьцаанд 300 төгрөгийн ногдол ашиг тараахаар гэж шийдвэрлэсэн.</p>	
10.	<p>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>	
	<p>Байхгүй</p>	
<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>		
Овог, нэр: <i>Ц. Цэндбаяр</i>		Овог, нэр:
Албан тушаал: "Баянгол Зочид Буудал" ХК-ийн гүйцэтгэх захирал		Албан тушаал: "....." ..К аудитын компанийн
Гарын үсэг: <i>Ц. Цэндбаяр</i>	(Тамга/тэмдэг)	Гарын үсэг:
<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>		
Овог, нэр: <i>Д. Саугасмаа</i>		
Албан тушаал: <i>ТТЗ-ийн /Харий бичиг /үргэлж гүйцэтгэгч</i>		
Гарын үсэг: <i>Д. Саугасмаа</i>		



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2023.03.20 № СТА/23-26
танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага(үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй

үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн хөдбөгдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд заасны дагуу зөвхөн “Баянгол Зочид Буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2023 оны 03 сарын 20



ДАЛТАНЦЭЦЭГ
Захирал, ММНБ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Тодруулга</u>	<u>2022.12.31</u>	<u>2021.12.31</u>
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	10,137,384.8	7,959,343.4
Дансны авлага	6	269,968.7	254,177.9
Татвар НДШ-ийн авлага		4,702.3	12,099.8
Бусад авлага	6	8,770,125.1	11,388,183.9
Бараа материал	7	1,195,335.4	1,025,065.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			
Эргэлтийн хөрөнгийн дүн		20,377,516.3	20,638,870.2
Үндсэн хөрөнгө	8	4,685,654.7	4,977,755.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9	10,540,933.7	6,967,803.5
Эргэлтийн бүс хөрөнгийн дүн		15,226,588.4	11,945,558.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		35,604,104.7	32,584,428.7
Дансны өглөг	10	595,108.7	259,215.8
Цалингийн өглөг		61,564.0	70,533.1
Татварын өр	11	239,743.9	125,533.5
НДШ-ийн өглөг		35,625.9	43,087.9
Ногдол ашгийн өглөг		301,275.3	309,361.8
Урьдчилж орсон орлого			
Бусад богино хугацаат өр төлбөр	12	15,148.5	9,998.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,248,466.3	817,730.1
Урт хугацаат зээл			
Урт хугацаат өр төлбөрийн дүн			
Нийт өр төлбөрийн дүн		1,248,466.3	817,730.1
Хувийн өмч /хувьцаат/	13	54,998.5	54,998.5
Халаасны хувьцаа		67,212.9	67,212.9
Нэмж төлөгдсөн капитал		102,280.6	102,280.6
Хуримтлагдсан ашиг		34,265,572.2	31,676,632.4
Эздийн өмчийн дүн		34,355,638.4	31,766,698.6
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		35,604,104.7	32,584,428.7

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Тодруулга</u>	<u>2022.12.31</u>	<u>2021.12.31</u>
<u>Борлуулалтын орлого (цэвэр)</u>	14	<u>6,465,758.3</u>	<u>2,849,950.8</u>
Борлуулалтын өртөг	15	3,578,599.3	2,139,470.4
<u>Нийт ашиг /алдагдал/</u>		<u>2,887,159.0</u>	<u>710,480.4</u>
Түрээсийн орлого		192,575.1	86,798.2
Хүүний орлого		56,335.9	54,304.9
Ногдол ашгийн орлого		-	
Бусад орлого		19,515.1	2,738.7
Борлуулалт, маркетингийн зардал	16	1,428,090.1	1,133,739.5
Ерөнхий ба удирдлагын зардал			
Санхүүгийн зардал			
Бусад зардал	17	305,824.7	64,819.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		1,305,595.3	-27,391.8
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
<u>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</u>		<u>2,727,265.6</u>	<u>-371,628.8</u>
Орлогын татварын зардал	18	138,325.8	5,401.1
<u>Татварын дараах ашиг (алдагдал)</u>		<u>2,588,939.8</u>	<u>-377,029.9</u>
Орлогын нийт дүн		<u>2,588,939.8</u>	<u>-377,029.9</u>
<u>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</u>			

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	54,998.5	67,212.9	102,280.6	32,049,693.0	32,139,759.2
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				3,969.3	3,969.3
Залруулсан үлдэгдэл	54,998.5	67,212.9	102,280.6	32,053,662.3	32,143,728.5
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-377,029.9	-377,029.9
Зарласан ногдол ашиг					
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	54,998.5	67,212.9	102,280.6	31,676,632.4	31,766,698.6
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	54,998.5	67,212.9	102,280.6	31,676,632.4	31,901,124.4
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,588,939.8	2,588,939.8
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	54,998.5	67,212.9	102,280.6	34,265,572.2	34,355,638.4

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөг/

<u>ҮЗҮҮЛЭЛТ</u>	<u>2022.12.31</u>	<u>2021.12.31</u>
Мөнгөн орлогын дүн (+)	<u>7,675,701.1</u>	<u>2,554,759.6</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,609,547.8	2,554,759.6
Буцаан авсан албан татвар		
Бусад мөнгөн орлого	66,153.3	
Мөнгөн зарлагын дүн (-)	<u>5,975,720.6</u>	<u>3,313,835.0</u>
Ажиллагчдад төлсөн	1,415,260.7	1,064,397.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	424,486.2	308,741.3
Бараа материал худалдан авахад төлсөн	2,825,900.5	1,680,945.6
Ашиглалтын зардалд төлсөн	349,223.9	44,958.0
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,098.5	10,900.9
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	692,296.9	203,469.9
Даатгалын төлбөрт төлсөн	9,571.9	421.9
Бусад мөнгөн зарлага	247,882.0	
<u>ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний</u>	<u>1,699,980.5</u>	<u>-759,075.4</u>
Мөнгөн орлогын дүн	<u>156,335.9</u>	<u>983,543.4</u>
Хүлээн авсан хүүний орлого	56,335.9	54,304.9
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт	100,000.0	929,238.5
Хүлээн авсан ногдол ашиг	-	
Мөнгөн зарлагын дүн	<u>975,783.8</u>	
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	100,000.0	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	700,000.0	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	175,783.8	
<u>ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</u>	<u>-819,447.9</u>	<u>983,543.4</u>
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Мөнгөн зарлагын дүн	<u>8,086.5</u>	<u>5,440.5</u>
Төлсөн ногдол ашиг	8,086.5	5,440.5
<u>СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>-8,086.5</u>	<u>-5,440.5</u>
Валотын ханшийн зөрүү	<u>1,305,595.3</u>	<u>-27,391.8</u>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>2,178,041.4</u>	<u>191,635.7</u>
<u>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	<u>7,959,343.4</u>	<u>7,767,707.7</u>
<u>Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	<u>10,137,384.8</u>	<u>7,959,343.4</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

